



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
БҮСИЙН ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭНИЙ
ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/162

Арвайхээр

Г

Журам батлах тухай


Г

Эрүүл мэндийн тухай хуулийн тухай 20 дугаар зүйлийн 20.2.2, 20.2.3 дахь заалт, Монгол улсын “Унах бэртэх эрсдэлийг үнэлэх түүнээс урьдчилан сэргийлэх арга” MNS 6211:2019 стандарт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/514 дугаартай “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар-аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөө батлах тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/566 дугаартай “Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар сайжруулах зарим арга хэмжээний тухай” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/220 дугаартай “Үйлчлүүлэгчийг аюулгүй тээвэрлэх журам” тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/352 дугаартай “Үйлчлүүлэгчийг зөв танин тодруулах журам” тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Бүсийн оношилгоо эмчилгээний төвөөр үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хэрэгжүүлж буй “Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах нийтлэг журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Унаж бэртэхээс сэргийлэх хяналтын хуудас”, “Орчны унах эрсдэл үнэлэх хуудас”, “Тусгай тэмдэглэгээ”-г хоёрдугаар хавсралтаар, Журмын хэрэгжилтийн хяналт үнэлгээг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангах нийтлэг журмыг 2023 оны 10 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг хангаж, журмыг хэрэгжүүлэн зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээ чанар аюулгүй байдлын албаны дарга (Ц.Лувсандамдин) тасгийн эрхлэгч, сувилахуйн арга зүйч нарт тус тус үүрэг болгосугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, зөвөлгөө өгч ажиллахыг Эмнэлзүйн эрсдэл хариуцсан Чанарын менежер (Л.Золзаяа), Чанарын менежер (Ж.Нарантуяа), Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрсдлийн менежер (Эрдэнэзул), Сувилахуйн тусламж үйлчилгээний эрсдэл хариуцсан ажилтан (Д.Баасанхүү) нарт тус тус үүрэг даалгасугай.

ЗАХИРАЛ  Г.ДАШЖАНЦАН

